Голын усны түвшин нь хур тунадасны хэмжээнээс шууд хамаарч 1.2 - 1.3 м хэлбэлзэнэ. Өвөлдөө зарим газраа тэс хөлддөг, зундаа үертэй үед 205 м³/сек хүртэл ус өнгөрөөдөг, урсгалын хурд нь 1.2 м/сек хүрнэ. Голын ус нь цэнгэг (0.2 - 0.4 г/л), гидрокарбонат - сульфат - натрийн найрлагатай. Хэнтийн нуруун дахь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт багтах Хагийн хар нуур, Номингийн голоос тус бүр эх авч, нийслэл Улаанбаатар хотын урд хэсгээр урсаж өнгөрөн Орхон голд цутгана. 11 сарын дундаас 4 сарын дунд хүртэл хөлдөнө.

2.7. Ордын гидрогеологийн нөхцөл

Ашиглалтын талбай нь гидрогеологийн ангиллаар Хангай - Хэнтийн гидрогеологийн тогтцод хамаарна. Энэ тогтцын тэжээгдлийн талбайн хэмжээ нь газрын доорх усны хуримтлалын хэмжээнээс олон дахин илүү байдаг онцлогтой.

“Заамарын эх-2” алтны шороон ордын талбайн гол давуу тал буюу онцлог нь алт агуулсан дэнжүүдийн цухуйц нь Туул голын усны төвшингээс дээш өргөгдсөн байдгаас шалтгаалан хурдасны зүсэлт хуурай, усгүй байдаг явдал юм. Туул голын орчин үеийн голдирол нь талбайтай ойролцоо (баруун хил орчим) байдаг. Голдирол нь эрчимтэй тахиралдсан байдаг. Голын татам нь хэдэн зуун метр өргөнтэй, усны төвшингээс 2-4 м өндөрт байна.

“Заамарын эх-2” талбайн дэнжүүд нь Туул голын баруун цутгалууд болох залуу хөндий, жалгануудаар хэрчигдсэн бөгөөд ихэнхдээ өргөргийн дагуу чиглэлтэй Сэвсгэр хурдсуудад алт агуулагддаг, зарим жалгануудад орд үүссэн (Баруун галт, Галт-2) жилийн ихэнхэд хуурай гэсэн нийтлэг шинжүүдтэй.

Ус нэвчимтгий үеийн зузаан нь маш тогтворгүй, ойролцоогоор 10 орчим м хүрдэг. Газрын доорх усны түвшингийн гүн нь 2 - 32 м - т хэлбэлзэнэ. Ихэнхдээ хур тунадсаар

тэжээгдэнэ. Голын хурдасны уст давхаргыг тэжээх юм уу, жалга судгийн булгаар усаа алддаг. Ус нэвчүүлэлт нь харьцангуйгаар муу, хувийн гарц нь 1.75 л/сек м, ундарга нь 1 -3 л/сек хүрдэг. Ус нь тунгалаг, өнгө, үнэр, амтгүй, цэнгэгээс шорвогдуу хүртэл эрдэсжилт нь 0.2 - 3.2 г/л.

Нуур намгийн хурдасны уст давхарга нь бага тархалттай, Заамарын хотгор, Цагаан нуурын хонхрын хамгийн нам хэсгүүдээр оршдог. Шавар, шавранцар, янз бүрийн ширхэглэг элс, хайрганцрын үет үеүдээс тогтоно. Үе үе хатаж байдаг жижиг нууруудтай холбоотой, нуурууд нь шорвог, ус нь бохир давслаг. Нууруудаас хамгийн том нь Цагаан нуур бөгөөд ус нь 3.5 г/л эрдэсжилттэй, гидрокарбонат - магни - натрийн найрлагатай юм.

Хүснэгт 11. Усны хими шинж чанар

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	мг/л	мг/экв	%, мг-экв/л		мг/л	мг/экв	%, мг-экв/л
Cl	142.00	4.00	41.17	Na ⁺ +K ⁺	23.30	1.01	10.43
SO ₄ ²⁻	60.00	1.25	12.87	NH ₄ ⁺	96.20	4.80	49.41
NO ₃ ⁻	0.04	0.00	0.01	Ca ²⁺	47.40	3.90	40.14
NO ₂ ⁻	4.00	0.06	0.66	Mg ²⁺	0.00	0.00	0.02
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.00	0.00	0.00
HCO ₃	268.40	4.40	45.29	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	474.44	9.72	100.00	Дүн	166.90	9.71	100.00

2.8.Хөрсөн бүрхэвч


Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Уулсзаамар” ХХК-ийн “Заамарын Эх-2” алтны шороон ордыг ашиглах төслийн хөрсний хээрийн суурь судалгааг “Саблайм” ХХК нь хийж гүйцэтгэлээ.

2.8.1. Хөрсний морфологийн шинж чанар

Зүсэлт №1

“Заамарын эх-2” алтны шороон орд төслийн талбайн хөрсний зүсэлтийг дараах байдлаар гарав.

- Байршил : Төв аймаг, Заамар сум
- Өндөр : 960м д.т.д
- Газрын гадарга : Уулын урд хормой
- Бичил гадарга : Хажуугийн налуу
- Налуу : 30-40° (градус)
- Чулууны бүрхэц, % : чулуурхаг
- Зонхилох ургамал : Үетэн улалж
- Ургамал бүрхэц % : 35-40%
- Хөрсний нэр : Уулын хүрэн хөрс



2.8.2. Үе давхарга (гүн, см)

- А (0-20см) хүрэн бор өнгөтэй, нягт, хуурай, чийглэг, ургамлын үндэс олон, чулуугүй, бөөмөрхөг бүтэцтэй. Дараагийн үе шат руугаа аажим шилжинэ. Давсны хүчилд буцлахгүй.

Уг хөрсний агрохимийн шинж чанарыг үзвэл өнгөн үе давхаргадаа урвалын орчин сул хүчиллэг, ялзмаг агууламж өнгөн үе давхаргадаа 2.0% буюу дунд зэрэг, үржил шимийн

хувьд 100 г хөрсөнд хөдөлгөөнт фосфор 1.1-2.3 мг буюу бага, хөдөлгөөнт кали 7.0-24.0 мг дунд зэргийн хэмжээгээр хангагдсан байна. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар, 0.1мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээ 26.6% байна.

2.8.3. Зүсэлт №2

- Байршил : Төв аймаг, Заамар сум
- Газрын гадарга : Уулын өвөр
- Бичил гадарга : Хажуугийн налуу
- Налуу : 30-40° (градус)
- Чулууны бүрхэц, % : хад асга чулуутай
- Зонхилох ургамал : Үетэн улалж
- Ургамал бүрхэц % : 25-30%
- Хөрсний нэр : Уулын хүрэн хөрс



2.8.4. Үе давхарга (гүн, см)

- А (0-15см) хүрэн бор өнгөтэй, нягт, хуурай, чийглэг, ургамлын үндэс олон, чулуутай, бөөмөрхөг бүтэцтэй. Дараагийн үе шат руугаа аажим шилжинэ. Давсны хүчилд буцлахгүй.
- В (15-40см) цайвар бор өнгөтэй, ургамлын үндэсгүй, чулуугүй, элсэнцэр, нягт, бөөмөрхөг бүтэцтэй, зузаан нь 21-40 см. Дараагийн давхаргад тод шилжинэ.
- С (40↓) цайвар өнгөтэй, үндэсгүй, элсэнцэр, чулуурхаг, нягт, хуурай, карбонатлаг, давсны хүчилд сул буцлана, чулуугүй.

Уг хөрсний агрохимийн шинж чанарыг үзвэл ялзмаг агууламж өнгөн үе давхаргадаа 1.03-0.06% буюу маш бага, үржил шимийн хувьд 100 г хөрсөнд хөдөлгөөнт фосфор 1.1-3.8мг буюу дунд зэрэг, хөдөлгөөнт кали 7-39мг дундаж хэмжээгээр хангагдсан байна. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр, 0.1мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээ 19.2% байна.

Хүснэгт 12. Хөрсний хими шинж чанар

Дээж №	Гүн см	рН	Давс %	ЦДЧ , dsm	СО	Ялзмаг %	Шингээгдсэн сууриуд, мг- экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
							Ca	Mg	PO	KO
1	0-20	7.45	0.04	0.083	0.0	1.45	13	6.2	0.7	16
2	0-20	7.41	0.02	0.03	0.0	0.96	11	2.2	0.9	13
3	0-20	8.94	0.03	0.063	0.0	0.76	14.0	3.2	0.7	17

Хүснэгт 13. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж №	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		2.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	0.001	0.001
1	0-20	11.8	48.3	22.3	7.9	6.9	2.8	17.6
2	0-20	15.4	47.5	20.5	6.7	5.9	4.0	16.6
3	0-20	19.9	47.3	16.7	1.3	9.3	5.6	16.2

2.8.5. Хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэл, бохирдол

Хүний үйл ажиллагааны нөлөөгөөс шалтгаалж ямар нэгэн химийн бодис болон биологийн элементээр хөрс бохирдож, хөрсөн дэх химийн бодис элементийн агууламж зөвшөөрөгдөх стандарт хэмжээнээс илүү болох үйл явцыг хөрс бохирдох гэнэ. Хөрс бохирдуулагч эх үүсвэрүүдэд янз бүрийн дэд бүтцийн байгууламжууд, техник тоног төхөөрөмжүүд, болон бусад сектороос ялгарч буй хорт нэгдлүүд, хог хаягдал, бохир ус гэх мэт эх үүсвэрүүд багтдаг. Хөрсний бохирдлыг ерөнхийдөө гарал үүслээр нь 3 ангилдаг.

1. Химийн
2. Биологийн
3. Механик

Хөрсний эвдрэл – Төслийн нийт талбайн хэмжээнд эвдрэл багатай боловч байгаль цаг уурын онцлог болох өдөр шөнийн агаарын температурын зөрүү, байгалийн шилжилтийн бүсэд байрладаг зэргээс шалтгаалан хөрс нь байгалийн үйл явцаар элэгдэл, эвдрэлд орох үйл явц их байна. Лабораторийн задлан шинжилгээний үзүүлэлтийг “Инженер Геодези” ХХК-ийн Хөрс Судлалын итгэмжлэгдсэн лабораторид дээрх үзүүлэлтүүдийг тодорхойлуулсан.

Хүснэгт 14. Хөрсний хүнд металлын агууламж

Дээж, №	Гүн см	Cr	Cd	Ni	Pb	Zn	Cu
1	0-20	22.5	-	10.7	33.6	15.9	30.1
2	0-20	14.6	-	32.5	11.7	34.7	15.7
3	0-20	15.1	-	32.5	24.5	59.7	21.4
MNS 5850:2019 Шавранцар		100.0	1.5	100.0	70.0	150.0	100.0
MNS 5850:2019 Элсэнцэр		60.0	1.0	60.0	50.0	100.0	60.0

2.9. Ургамлан нөмрөг

“Заамарын эх-2” алтны шороон ордын төслийн талбайд хийсэн ургамлын аймаг, ургамалжилтын хээрийн судалгааны ажлын үр дүн болон төслийн үйл ажиллагааны улмаас төслийн талбай, түүний орчмын нутгийн ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөллүүд, тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүдийн талаар тодорхой хэмжээнд авч үзлээ. Мөн төслийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга

хэмжээнүүдийн үр дүнг тогтоох зорилгоор хийгдсэн ургамлын аймаг, ургамалжилтын хяналт шинжилгээний арга хэмжээнүүдийг тусгав.

2.9.1. Ургамлын зүйлийн бүрдэл

Судалгааны дүнд нийт 37 овог 93 төрөлд хамаарагдах 130 зүйл дээд ургамал бүртгэгдсэн. Бүртгэгдсэн нийт ургамлыг амьдралын хэлбэрийн хувьд ангилбал олон наст өвс (48%), сөөг, заримдаг сөөг (21%) зонхилох хувийг эзэлж байна. Мөн ургамлуудыг экологийн бүлгээр буюу амьдрах орчиндоо хандах байдлаар нь ангилан авч үзвэл хуурайсаг буюу ганд тэсвэртэй (ксерофит, мезоксерофит) ургамлын зүйлүүд ихэнх хувийг нь бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд төслийн талбай болон түүний ойр орчмын нутаг дэвсгэрт хуурайсаг, хуурайсаг - чулуусаг, элссэг сөөг, заримдаг сөөг ургамлууд уулын хээр, хээрийн бүсийн онцлогт зохилдон тархжээ. Одоохондоо нэг ба хоёр наст хөл газрын ургамал цөөн тоогоор дайралдаж байна. Түүнчлэн бүртгэгдсэн ургамлын зүйлүүдийн дотор хээрийн бүсийн бэлчээрийн хэв шинжийг бүрдүүлэгч бэлчээр, тэжээлийн ургамлууд олноор тохиолдож байна (*Stipa krylovii*, *S. sibirica*, *Poa attenuata*, *Caragana microphylla*, *Festuca lenensis*) зэрэг 73 ургамлыг нэрлэж болно.

Алт олборлолтын талбай дахь ургамалжилтын бүтэц бүрэлдэхүүнд дараах бүлгэмдлүүд зонхилж байна. Үүнд: 1. **Шивэт хялгана – Хазарганат - Алаг өвст бүлгэмдэл** нилээд хувийг эзэлж байна. Тухайлбал тус бүлгэмдэл нь 70-80% бүрхэцтэй байх ба хялганат хээрийн бүлгэмдэлд *Stipa krylovii*, *S. sibirica*, *Adenophora stenanthina*, *Leymus chinensis*, *Agropyron cristatum*, *Potentilla tanacetifolia* зэрэг зүйл нь 1-р ташингад байхад, 2-р ташингад *Poa attenuata*, *Caragana microphylla*, *Festuca lenensis*, *Iris tigridia*, *Iris flavissima*, *Artemisia frigida*, *Cleistogenes squarrosa*, *Veronica incana* зэрэг зүйлүүд орно.

Зураг 5. Төслийн талбай орчим тархсан ургамалжилт



Cleistogenes squarrosa



Stipa krylovii,

Шивэт хялгана -Навтуулт бүлгэмдэл. Тус бүлгэмдэл нь энд 40-45% бүрхэцтэйгээр тааралдана. Зонхилох зүйлийн тоонд *Stipa krylovii*, *Potentilla acaulis*, *Polygonium divaricata*, *Leuzea uniflora*, *Bupleurum scorzonnerifolium*, *Schizonepeta multifida*, *Orostachys malacophylla*, *Leontopodium leontopodioides*, *Chamaerhodos erecta* зэрэг зүйлүүд багтана.

Зураг 6. Төслийн талбай орчим тархсан ургамалжилт



Potentilla acaulis



Leuzea uniflora

Агь - дэгнүүлт жижиг үетэн - алаг өвст бүлгэмдэл. Энэ нь ашиглалтын талбай, толгодын оройн хэсэг, мөн лицензийн талбайд дахь толгодуудын оройн хэсгээр зонхилон ургаж байна. Тухайн бүлгэмдлийн ургацын бүрхэц нь 35-40 % байна. Зонхилох зүйлүүдэд *Artemisia frigida*, *Poa attenuata*, *Festuca lenensis*, *Koeleria macrantha*, *Carex korshinskyi*, *Allium bidentatum*, *Lilium pumilum*, *Silene jensseensis* бүлгэмдлийг бүрдүүлж байна.

Зураг 7. Төслийн талбай орчим тархсан ургамалжилт



Artemisia frigida



Lilium pumilum

Аж ахуйн ач холбогдол, статусаар нь ангилан авч үзвэл тухайн нутагт элбэг зүйл 78, нэн ховор ба ховор зүйл 26, хүнсний ургамал 12 зүйл, эмийн гоц ашигтай 38 зүйл, бэлчээрийн 58 зүйл байх ба хөл газрын ургамал 12 зүйл тус тус байна.

2.10. Амьтны аймаг

Нутгийн хойд ба өмнөд хэсгийн байгалийн нөхцөл, дулаан, хүйтэн, чийг, усны хангамж зэргийн ялгаанаас болоод амьтадын төрөл зүйл өөр өөр байдаг. Ан агнуурын хуулийн заалт ёсоор амьтныг

1. Нэн ховор
2. Ховор
3. Элбэг гэж гурван зэрэгт хуваана.

Төсөл хэрэгжих орчмын нутаг дэвсгэрт 21 зүйлийн хөхтөн амьтан, 119 орчин зүйлийн шувуу, 1 зүйлийн мөлхөгч, 2 зүйлийн хоёр нутагтан тус тус бүртгэжээ. Эндэх хөхтний 90 гаруй хувь нь манай орны хамгийн ерийн амьтад юм. Хөхтний зүйлийн бүрэлдэхүүний 80 гаруй хувь нь шавж идэштэн, туулай хэлбэртэн, мэрэгч зэрэг жижиг хөхтөн юм. Жижиг хөхтөн нь тус нутгийн амьдас нийцэд (биоценозод) нэн чухал өргөн оролцоо холбогдолтой. Хөхтний 9 зүйл (39%) уламжлалт агнуурын холбогдолтой боловч тухайн нутагт агнуурын нөөцгүйд тооцогддог.

2.11. Тусгай хамгаалалттай газар нутаг ба түүх соёлын дурсгалт зүйлс

Төв аймгийн Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутгийн хилийг зааглах Туул голын хөндий бол нэн эртний чулуун зэвсгийн үеэс эхлэн хүн нутаглаж байсан оромж, бууц, хүрэл-төмөр зэвсгийн үеийн дурсгал, буган чулуун хөшөө, хүн чулуун хөшөө, хадны сүг зураг, хөшөө дурсгал, хот суурины дурсгал, соёлын их түүхтэй газар юм. Энэ бүс нутагт Хүннү, түүний дараа оршин тогтнож байсан Сяньби, Түрэг угсааны эртний улсууд (Түрэг, Уйгар, Киргиз), түүх соёлын дурсгалаа үлдээжээ. МЭ 10-р зууны үеэс эртний овог аймгууд, Монголын эзэнт гүрний үеэс Чингис хааны отгон хүү Тулуйн эзэмшил нутаг байжээ.

2.12. Нийгэм, эдийн засаг

Заамарын эх-2 алтны шороон орд нь Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутагт орших ба Улаанбаатар хотоос хойш 145 километр зайд оршино.

Тус сум нь Улаанбаатар хотоос 180 км, аймгийн төвөөс 225 км алслагдан оршдог бөгөөд Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Лүн сум, Булган аймгийн Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилэн, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумтай хиллэж нийт 280.3 мян.га нутаг дэвсгэрийг эзэлдэг. 2024 оны байдлаар Заамар сумын хувьд нийт 5556 хүн ам, 1713 өрх айл амьдарч байна. Сумын хүн амын нягтрал 2.1 хүн/км.кв байгаа нь Төв аймгийн бусад сумуудтай харьцуулахад бага нягтралтай байна. Заамар сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болох 4 багтай.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ, ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Газрын гадарга хэвлий: Тус төсөл хэрэгжихэд нийтдээ 200.63 га талбайг эзэмших бөгөөд уурхайн үйл ажиллагааны улмаас уурхай, барилга байгууламж, зам тээвэр, хөрсний овоолгын талбайг хамарсан эвдрэл үүсэж байгаль орчинд сөрөг нөлөө учруулна. Ордыг ашигласнаар газрын гадаргууг тодорхой хэсэгт өөрчлөхөөс гадна хөрсний бүтэц, дүүргийн гидрогеологийн горимыг өөрчилдөг.

Агаарын чанар:

- Уурхайн үйл ажиллагаанаас агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүсгэх гол хүчин зүйлүүд /усан халаалтын зуух, овоолго, гадаад дотоод тээврийн зам, олборлолтын үйл ажиллагаа,/
- Олборлох, тээвэрлэх явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий гэх мэт/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын хими болон физик шинж чанарт нь сөрөг нөлөөлөл үзүүлэх болно.
- Уурхайн дэд бүтэц нь нэг гол агаар бохирдуулагч эх үүсвэр болдог. Газрын хэвлийг хөндөх, хаягдлын овоолго үүсгэх, хүдэр ачих овоолго үүсгэн хадгалах зэргээс орчны агаар дахь тоосжилтыг нэмэгдүүлдэг нь төлөвлөж буй ил уурхай нь агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Уурхайн үйл ажиллагааны үед хөрс чулуулгийн гаралтай тоос тоосонцор ихээр үүсдэг.
- Уурхайн барилга байгууламжийн дулааныг хангах үүднээс уурын зуухыг ашиглах бөгөөд үүнээс үүдэн агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүснэ.

Хөрсөн бүрхэвч:

- Уурхайн хил хязгаар дотор ашигт малтмал олборлоход хөрс хуулалтаас хөрс эвдрэх.
- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах.
- Уурхайд хөрсний овоолго хийх, хөрс тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд хүнд даацын олон машин ажиллахад хөрс их хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орж, хөрсний үржил шим алдагдана.
- Хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, хуурайших.
- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах.
- Хүдэр, хөрс тээвэрлэх явцад талбайд элдэв хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, дагтаршсан шороон хэсэг суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай, салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Үерийн усанд зам, талбай эвдрэх .

Усан орчин:

- Аадар борооны үед тус талбайн баруун талаас гол үерлэж талбай дахь хөрс, шавар, хатуу шингэн хог хаягдал, хагшаас зэргийг урсгаж усыг бохирдуулж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Газар шорооны ажлын үед газрын доорх ус агуулсан үеийг ухаж хөндөх нь газрын доорх усыг бохирдуулах магадлалтай.

Ургамлан нөмрөг:

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болно,
- Газар шорооны ажлын үед ургамлын үе хөрсийг хуулах,
- Төслийн түүхий эд, материалыг зөөх тээвэрлэх,
- Хөрс хуулах, хөрсний овоолго хийх,
- Төслийн явцад бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, хувьсаж өөрчлөгдөх сөрөг нөлөөлөлтэй.

Амьтны аймаг:

- Ордыг ашиглах төсөл хэрэгжүүлэх хугацаанд хүн, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс, үүний хамтаар, уурхайн үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
- Дээрх төрлийн сөрөг нөлөөллөөс шалтгаалан орчны бүс дэх амьтад идээшсэн нутгаасаа дүрвэн зайлах, байршил нутгаа өөрчлөх зэрэг хариу үйлдэл гаргах бөгөөд энэ явцдаа олноор тэжээлийн хомсдол ба орчны өөрчлөгдлийн улмаас үхэж үрэгдэх, бусад махчин амьтдын идэш болох зэрэг зүй бус хорогдолд өртөж болзошгүй юм.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 2026

“Уулсзаамар” ХХК-ийн “Алтны шороон орд ашиглах” төслийн БОННУ-ний ажлыг Монгол улсын Байгаль хамгаалах тухай хууль болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д заасны дагуу болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд заасны дагуу хийж төслийн хэрэгжилтийн явцад авч хэрэгжүүлэх тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаа.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан ОУ-ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хуулинд заасны дагуу тус төлөвлөгөөнд нэгтгэн ашигласан болно.

4.1.Хамрах хүрээ

БОМТ 2026 нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгэм хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- Төслийн хүрээнд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах,
- Төслийн хаалт нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах
- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зардлыг тусгах
- Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох
- БОМТ түүний хэрэгжилтэнд оролцогч талуудыг тодорхойлж, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;

4.2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН							
1	Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлийн үед тоосжилт, ослын эрсдэл нэмэгдэх	Цаг уурын урьдчилсан болон аюулт үзэгдлийн мэдээг тогтмол авч, уурхайн үйл ажиллагаанд ашиглах	Уурхайн нийт үйл ажиллагаа	500.0/жил	500.0/жил	2026–2029 он, сар бүр мэдээлэл авч ашиглах	Агаарын тухай хууль; Гамшгаас хамгаалах тухай хууль; MNS 4585:2025
2	Уурхайн техник, тээврийн хэрэгслийн яндангаас хорт хий ялгарах	Тээврийн хэрэгсэл, экскаватор, бульдозер болон бусад техникийн хөдөлгүүр, яндангийн утаанд үзлэг хийж, техникийн тохиргоо, засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайд ашиглах бүх машин механизм	1,000.0/жил	1,000.0/жил	Жилд 1 удаа болон шаардлагатай үед	MNS 5013:2009; MNS 4990:2010; MNS 4585:2025
3	Хүнд даацын автомашины хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Уурхайн дотоод замд хурдны хязгаар тогтоож, хурд хязгаарлах, чиглэл заах болон анхааруулах тэмдэг байрлуулах, эвдэрсэн тэмдгийг сэргээх	Дотоод тээврийн зам	3,000.0		2026 онд байршуулж, дараагийн жилүүдэд засварлана	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль; MNS 4596:2014
4	Дотоод тээврийн зам, олборлолтын талбайгаас тоос босох	Хуурайшилт ихтэй болон салхитай өдрүүдэд дотоод тээврийн зам, ачих, буулгах талбайд усалгаа хийх	Уурхайн дотоод зам болон идэвхтэй ажлын талбай	ҮАЗ		Олборлолтын улиралд, шаардлагатай үед	MNS 4585:2025; Ус ашиглуулах зөвшөөрөл
5	Тоосжилтын эх үүсвэрийн мэдээлэл бүртгэлгүй байх	Техник хэрэгслийн ажилласан цаг, түлшний хэрэглээ, тээврийн рейс, замын усалгаа болон тоосжилт үүсгэгч эх үүсвэрийн бүртгэл хөтлөх	Уурхайн нийт үйл ажиллагаа	500.0/жил	500.0/жил	Сар бүр бүртгэж, жил бүр нэгтгэн тайлагнах	Агаарын тухай хууль; БОМТ-ийн хэрэгжилтийн тайлагнал
6	Салхи ихтэй үед хөрс хуулалт, олборлолтоос тоосжилт ихсэх	Хүчтэй салхи, шороон шуургатай үед шимт хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлтийн ажлыг түр хязгаарлах	Уурхайн ашиглалтын талбай	ҮАЗ		Шаардлагатай үед	Компанийн дотоод журам; ХАБЭА-н заавар

7	Замын гадарга эвдэрч, тоосжилт нэмэгдэх	Дотоод тээврийн замыг хусаж тэгшлэх, нүх эвдрэлийг засах, шаардлагатай хэсэгт хайрга дэвсэж нягтруулах	Уурхайн дотоод зам	ҮАЗ		Олборлолтын улиралд	Уулын ажлын төлөвлөгөө
8	Орчны агаарын чанар муудах	TSP, PM ₁₀ , PM _{2.5} болон шаардлагатай бусад үзүүлэлтээр орчны агаарын хэмжилт, шинжилгээ хийлгэх	ОХШХ-д заасан 4 цэг	ОХШХ		Жилд 2 удаа, 5 болон 9 дүгээр сард	MNS 4585:2025; MNS 4990:2010
	Агаар орчны дүн				2,000.0		
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ							
9	Шимт хөрсний нөөц алдагдах, бусад хөрстэй холилдох	Ашиглалтад өртөх талбайн шимт хөрсийг уулын ажлын төлөвлөгөөний дагуу хуулж, тусгай овоолгод хадгалах, овоолгын хил, хэмжээг тэмдэгжүүлэх	72.71 га талбайн үе шаттай ашиглалт	Уулын ажлын зардалд		Газар хөндөхийн өмнө	MNS 5914:2008; MNS 5916:2008
10	Шимт хөрсний овоолго салхи, усны элэгдэлд өртөх	Шимт хөрсний овоолгын налууг тогтворжуулах, салхи, усны элэгдлээс хамгаалах, удаан хадгалах хэсгийг олон наст ургамлын үрээр түр ургамалжуулах	Шимт хөрсний овоолго	2,000.0/жил	2,000.0/жил	2026–2029 он	MNS 5917:2008; MNS 5918:2008
11	Төлөвлөөгүй газар эвдрэх, салаа зам үүсэх	Карьер, овоолго, тээврийн замын хил, хөдөлгөөний чиглэлийг тэмдэгжүүлж, салаа зам гаргахыг хориглосон самбар байрлуулах	Уурхайн ашиглалтын талбай	ҮАЗ		Жил бүр шалгаж засварлах	Газрын тухай хууль; Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
12	Шатах тослох материал асгарч хөрс бохирдох	ШТМ хадгалах болон техник засварлах хэсэгт асгаралтын иж бүрдэл, шингээгч материал, тосгуур сав, бохирдсон хөрс түр хадгалах битүү сав байрлуулах	ШТМ-ын цэг, техник зогсоол	2,000.0/жил	2,000.0/жил	Жил бүр шинэчилж, байнгын бэлэн байдалд байлгах	MNS 5850:2019; Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
13	Газрын гадарга эвдэрч, ургамлан нөмрөг устгах	Олборлолт дууссан хэсэгт үе шаттай нөхөн сэргээлт хийж, шимт хөрс тараасны дараа нутгийн ургамлын үрээр нөхөн үрлэгээ хийх	Олборлолт дууссан хэсгүүд	НСЗ		2026–2029 он, олборлолттой зэрэгцүүлэн	MNS 5918:2008; Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал

14	Борооны усны урсацад хөрс угаагдаж, эвдрэл нэмэгдэх	Карьер, хөрсний овоолгын орчимд түр ус зайлуулах суваг, шороон хаалт хийх, эвдэрсэн хэсгийг засах	Идэвхтэй олборлолтын талбай	2,000.0/жил	2,000.0/жил	Хур борооны улирлын өмнө, шаардлагатай үед	MNS 5917:2008; Газрын тухай хууль
15	Нөхөн сэргээсэн талбайн ургамлын ургалт муу байх	Нөхөн сэргээсэн талбайн ургамлын бүрхэц, соёололт, хөрсний тогтворжилтыг шалгаж, шаардлагатай хэсэгт нөхөн үрлэгээ, арчилгаа хийх	Үе шаттай нөхөн сэргээсэн талбай	НСЗ		Жилд 1 удаа, ургамлын ургалтын үед	MNS 5918:2008; ОХШХ
16	Техникийн нөхөн сэргээлт хийгдээгүйгээс карьер, овоолго үлдэх	Олборлолт дууссан хэсгийг дотоод овоолгоор нөхөн дүүргэх, гадаргыг тэгшлэх, налууг аюулгүй хэлбэржүүлэх	Нийт 72.71 га талбайд үе шаттай	Уулын ажлын болон нөхөн сэргээлтийн зардалд		Олборлолттой зэрэгцүүлэн болон уурхайн хаалтын үед	MNS 5916:2008; MNS 5917:2008
	Газрын гадарга, хөрс, ургамлын дүн				4,000.0		
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС							
17	Усны нөөцийг үр ашиггүй ашиглах	Усны хэрэглээг хэмнэх, алдагдлыг бууруулах, усны бүртгэл хөтлөх талаар ажиллагсад сургалт зохион байгуулах	Уурхайн ажиллагсад	500.0/жил	500.0/жил	Жилд 1 удаа	Усны тухай хууль
18	Зөвшөөрөл, дүгнэлтгүйгээр ус ашиглах эрсдэл	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг тухайн жилийн ус ашиглалтын хэмжээнд үндэслэн гаргуулж, төлбөрийг хугацаанд нь төлөх	Уурхайн ус хэрэглээ	ҮАЗ		2026–2029 он	Усны тухай хуулийн 28 дугаар зүйл
19	Гүний усны түвшин буурах, тоолуурын бүртгэл алдагдах	Гүний худгийн тоолуурын бүрэн бүтэн байдлыг шалгах, усны түвшин хэмжиж бүртгэх, хэмжилтийн багажийн засвар үйлчилгээ хийх	Уурхайн гүний худаг	1,000.0/жил	1,000.0/жил	Улиралд 1 удаа	MNS 0900:2018; Усны тухай хууль
20	Хурын ус, лаг шавар Туул гол руу дамжин усны чанарт нөлөөлөх	Олборлолтын талбай, хөрсний овоолго, замын ус зайлуулах суваг болон лаг барих түр хаалтыг цэвэрлэж, засварлах	Карьер, овоолго, зам орчим	1,500.0/жил	1,500.0/жил	Хур борооны улирлын өмнө болон дараа	MNS 4586:1998; MNS 4943:2015
21	ШТМ-ын асгаралт гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх	Усны хамгаалалтын бүсэд шатахуун, тослох материал хадгалахгүй байх,	ШТМ-ын цэг, Туул голын	500.0/жил	500.0/жил	Тогтмол	Усны тухай хууль; Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын

		асгаралтын үед тархалтыг зогсоох материал бэлтгэх	хамгаалалтын бүс орчим				хамгаалалтын бүсийн тухай хууль
22	Туул гол болон гүний усны чанар өөрчлөгдөх	Туул гол, гүний худаг болон шаардлагатай бусад хяналтын цэгээс усны дээж авч, лабораторийн шинжилгээ хийлгэх	ОХШХ-д заасан цэгүүд	ОХШХ	–	ОХШХ-д заасан давтамжаар	MNS 4586:1998; MNS 0900:2018
	Усан орчны дүн				3,500.0		
АМЬТНЫ АЙМАГ							
23	Автомашинны хөдөлгөөнөөс амьтан дайруулах, үргээх	Амьтан нэвтрэх боломжтой замын хэсэгт хурдны хязгаар болон амьтан хамгаалах анхааруулах тэмдэг байрлуулах	Дотоод тээврийн зам	900.0		2026 онд байршуулж, эвдэрсэн үед засварлах	Амьтны тухай хууль
24	Амьтан карьер, суваг, ухашид унах	Карьер болон ус зайлуулах сувагт амьтан гарах боломжтой налуу гарц үлдээж, аюултай хэсгийг түр хаалт, тэмдэглэгээгээр хамгаалах	Карьер, суваг, ухашийн хэсэг	200.0		Олборлолтын явцад	Амьтны тухай хууль; Уулын ажлын аюулгүй ажиллагааны дүрэм
25	Хууль бус ан агнуур, амьтны амьдрах орчныг санаатайгаар сүйтгэх	Ажиллагсад ан амьтан хамгаалах сургалт зохион байгуулж, хууль бус ан агнуурыг хориглосон дотоод журам мөрдүүлэх	Уурхайн ажиллагсад	500.0/жил	500.0/жил	Жилд 1 удаа	Амьтны тухай хууль
	Амьтны аймгийн дүн				1,100.0		
НИЙГЭМ, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД							
26	Уурхайн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол шийдвэрлэгдэхгүй байх	Орон нутгийн иргэдийн санал, гомдлыг хүлээн авах бүртгэл ажиллуулж, шийдвэрлэсэн арга хэмжээний талаар эргэн мэдээлэх	Төсөл хэрэгжих орон нутаг	500.0/жил	500.0/жил	Жил бүр, шаардлагатай үед	Байгаль орчныг хамгаалах тухай хууль; Компанийн дотоод журам
27	Тоосжилт, дуу чимээ, техник хэрэгслийн хөдөлгөөнөөс ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	Ажиллагсад тоосжилт, дуу чимээ, хөдөлмөр хамгаалал, хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээний сургалт зохион байгуулах	Уурхайн ажиллагсад	1,000.0/жил	1,000.0/жил	Жилд 1 удаа, шинэ ажилтан бүрд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль; MNS 4990:2010; MNS 5002:2000

	Нийгэм, хүний эрүүл мэндийн дүн				1,500.0		
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					16,000.0		

4.3.Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Төслийн эхний жилд техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй ба 2027 онд техникийн нөхөн сэргээлтийн ажил эхэлж 2028 оноос биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсан.

4.4.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Олборлолтын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул, төслийн нөлөөлөлд өртсөн ба Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоох, дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутгийн байршлыг сонгох, биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн арга хэмжээг тогтоох, мониторинг хийх хөтөлбөр зохиох, төсөв, санхүүжилтийн төлөвлөгөө гаргах гэсэн үндсэн шат дараалалтайгаар дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

- Дүйцүүлэн хамгаалах талбайг орон нутгийн байгууллагатай хамтран сонгох
- Амьтдын усан хангамж ашигладаг орчныг хамгаалах, тэмдэгжүүлэх
- Хууль бус мод огтлолт, ан агнуураас урьдчилан сэргийлэх мэдээллийн самбар байрлуулах
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийн тайлан боловсруулах

Хүснэгт 16. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Дүйцүүлэн хамгаалах талбайг орон нутгийн байгууллагатай хамтран сонгох	Олборлолт хийгдсэн талбай	-	7,500.0		2026 онд багтаах	БОНБУ-ний тухай хуулийн 3.1.11, 9.6. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам

4.5. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд хөтөлбөр

Төсөл хэрэгжүүлэгч “Уулс заамар” ХХК нь Хайлааст багийн нутагт жил бүр 500 мод тарихаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 17. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод, сөөгийн төлөвлөгөө

Ашиглалтын жил	Хайлаас	Бургас	Улиас	Нийт
1-р жил	200	100	200	500

Хүснэгт 18. Суулгац, модны үнэ

Модны төрөл	Тоо (ширхэг)	Сонгосон суулгац	Нэгж үнэ (төг)	Нийт (төг)
Хайлаас	200	3 настай (90–100 см)	1,500	300,000
Бургас	100	3 настай (180–250 см)	3,000	300,000
Улиас	200	3 настай (130–180 см)	3,500	262,500

Хүснэгт 19. Тариалалтын нийт зардал

№	Үзүүлэлт	Тооцооллын үндэслэл	Жилийн хэмжээ
1	Тарих мод, бутны тоо	Жил бүр 500 ширхэг мод, бут тарих	500 ш
2	Суулгац худалдан авах зардал	500 ш × 5,000 төг	2.5
3	Тарилт, нүх ухалт, суулгалтын зардал	Суулгацын тээвэр, нүх ухалт, суулгалт	1
4	Усалгааны усны хэрэгцээ	1 мод/бутанд 40–60 л/жил	25 м³
5	Усалгаа, арчилгааны зардал	Эхний 2–3 жилд усалгаа, хөрс сийрүүлэх, нөхөн тарилт хийх	0.8
6	Хашаалалт, хамгаалалт	Мал, мэрэгч, хүний нөлөөллөөс хамгаалах	0.6
7	Хяналт, мониторинг	Амьдрах чадвар, ус ашиглалт, нөхөн тарилтын хяналт	0.4
Нийт			4.3

Тарих хугацаа

Намрын тарилт

- 9 дүгээр сарын 10 – 10 дугаар сарын 5
- Навч унасны дараа, хөрс хөлдөхөөс өмнө тарих.

4.6.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 20. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ба түүний зардал

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	1	2	3	4	5	6	7
	Хээрийн түймэр уурхайн талбай, кемп рүү орж ирэх, уурхайн хээрийн түймэрт өртөх	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулах	Төслийн талбайн байршилд	1	Үйл ажиллагааны зардал		2026
	Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаах дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Дотоод төлөвлөлтөд	1	Дотоод журам		2026
		Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	Ажилчдад	1	300	300	2026
		Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Төслийн талбайд	1	Үйл ажиллагааны зардалд		2026
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Төслийн талбайн байршилд, кемп-д	1	Үйл ажиллагааны зардалд		2026
	Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	Төсөл хэрэгжих хугацаанд	Өдөр бүр	-		2026
		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Төслийн ажилчдад	1	500	500	2026

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	1	2	3	4	5	6	7
		Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	Кемп, уурхайн ажлын талбарын ойролцоо	1	2,500	2500	2026
		Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Төслийн ажилчдад	1	Үйл ажиллагааны зардалд		2026
	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Төслийн ажилчдад	1	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан		2026
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал					3,300		

4.7.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 21. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Үйл ажиллагааны турш	500.0	500.0	2026	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, түр хадгалан Заамар сумын эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төвлөрсөн хогийн цэгт тээвэрлүүлэх, шингэн хог хаягдлыг зориулалтын битүү байгууламжид хуримтлуулж, тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар тогтмол соруулан зайлуулах.	Үйл ажиллагааны турш	1,000.0	1,000.0	2026	
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	200.0	200.0	2026	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйл ажиллагааны турш	1 500.0	1,500.0	2026	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Үйл ажиллагааны турш	Хэрэглээний хэмжээгээр		2026	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	200.0	200.0	2026	

	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	-	Үйл ажиллагааны зардалд		2026	
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	-	ҮАЗардалд тусгах	2026	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
Нийт дүн				3,400.0		

4.8.БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч “Уулс Заамар” ХХК жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

Хүснэгт 22. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Булган аймгийн Бүрэгхангай сумын орон нутгийн нөлөөллийн бүсэл байрлаж буй иргэд, Засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгч	ИТХ хэлэлцүүлэг, илтгэл, нөлөөллийн бүсийн иргэдтэй хийсэн уулзалт	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар танилцуулж санал авах	9-р сард	Байгууллагын дотоод зардал	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	Бүрэгхангай сум
2	Булган аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэгт	Илтгэл, тайлан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлэх	10-р сард	Байгууллагын дотоод зардал	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	Булган аймаг, Бүрэгхангай сум
3	БОАЖЯ	БОМТ 2024-ийн биелэлтийн тайлан биелэлтийн тайлан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлэх, батлуулах	12-р сард	Байгууллагын дотоод зардал	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	БОАЖЯ

4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтэнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтануудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Хүснэгт 23. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Гэрээний үнийн дүнгээр	Өмнө хийлгэснээс 5 жилийн дараа	Газрын тухай хуулийн 58.5
Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментын төлөвлөгөө боловсруулах	Уурхай хаагдахаас 3 жилийн өмнө	--*--	--*--	БОНБУнэлгээний тухай хуулийн 14.1.3-т зааснаар
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	тохиролцох	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Нийт, сая.төг		-		

4.10. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Уулс Заамар” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ -тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.


Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Уулс Заамар” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Уулс Заамар” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

Хүснэгт 24. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын тоосны шинжилгээг хийлгэх /Нийт тоосонцор, PM10, PM2.5/	Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 4 цэг	5, 9-р сард	78,400 х жилд 2 удаа х 4 цэг 627,200	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх /SO ₂ , NO ₂ /	Уурхайн үйл ажиллагаанаас агаарт бохирдуулагчийн хэмжээг тогтоох				
1.3	Угаарын хий тодорхойлох	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр угаарын хий үүсэх				
1.4	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа хөдөлгөөнөөр шуугиан үүсэх				
Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс, ялзмагийн агууламж, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 4 цэг	5, 9-р сард	4 цэгт х 2 удаа х 20.0 мян.төг НИЙТ 160 /Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж - 20.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга,

2.2	Хүнд металлын агууламж	Уурхайн олборлолтын хэсэг, зам		5, 9-р сард	4 цэгт х 1 дээж х жилд 2 удаа х 33.0 х 4 жил Нийт 264 /Хүнд металлын шинжилгээ 1 дээж-33.0 төг/	MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усны хяналт шинжилгээ						
2.1	Химийн ерөнхий шинжилгээ	Гүний усанд	Гүний худагт Голын ус	5, 9-р сард	Усны шинжилгээ 150.0 х 2 цэг х 2 удаа х 4 жил = 600 Худгийн түвшин хэмжилт 1 худаг х 1 удаа х 50.0 х 4 жил =200.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2.2	Микробиологийн шинжилгээ	Гүний худагт		5, 9-р сард		
2.3	Усны түвшин усны ундарга, нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх		5, 9-р сард		
Ургамлын аймаг						
3.1	Ургамал устгах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биоамасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 4 цэгт	Жилд 1 удаа	1,000.0 х 2 жил = 1,000.0	ШҮА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах Байгалт орчны мэргэжилтэн
3.3	Тарьсан модны өсөлт, амьдралын тооллого	Уурхайн кемп орчим	Уурхайн суурин	Жилд 1 удаа	50.0 НИЙТ 2,200.0	Гэрээт ургамал судлаач ажиллуулах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					2,094.4	



Зураг 8. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр мониторингийн дээж авах цэгийн байршил

4.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал ба задаргаа

Хүснэгт 25. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал ба задаргаа

№	Байгаль хамгаалах арга хэмжээний зардал	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	16,000,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	2026 онд нөхөн сэргээлт хийгдэхгүй
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	7,500,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	2,000,000
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3,300,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,400,000
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
9	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
10	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд	5,300,000
Байгаль хамгаалах арга хэмжээний зардлын нийт хэмжээ		37,500,000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр		2,094,000

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамын 2.3-т заасны дагуу төлвөл зохих дүн болох 50%-ийн барьцаа буюу 18,750,000 төгрөгийн төрийн сангийн тусгай дансанд байршуулав.



цахим гүйлгээний мэдээлэл

шилжүүлэгчийн мэдээлэл		хүлээн авагчийн мэдээлэл	
Банкны нэр:	ХасБанк	Банкны нэр:	Төрийн сан
Данс:	5599115211	Данс:	100900013406
Нэр:	УУЛС ЗААМАР ХХК	Нэр:	БО нөхөн сэргээх баталгаа
Валют:	MNT	Валют:	MNT

гүйлгээний мэдээлэл			
Гүйлгээний дугаар :	000277861653	Гүйлгээ хийсэн огноо :	2026-07-31 13:35:48
Гүйлгээний дүн :	MNT 18,750,000.00	Гүйлгээний шимтгэл :	MNT 300.00
Гүйлгээний утга:	БОМТ барьцаа 2026 /уулс заамар ХХК 28199 96/		-

Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах, мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.

